



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар A/212

Хэрлэн сум

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалт, лабораторийн шинжилгээний ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалт, лабораторийн тандалт шинжилгээний ажлыг орон нутагтаа төлөвлөгөөт хугацаанд нь шуурхай зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалт, тандалт, шинжилгээнд шаардагдах био бэлдмэл, эмийн бодис, мэргэжлийн удирдлага, заавар зөвлөмжөөр хангах, дархлаажуулалтын явц, технологи, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



سفر مجلس
کتابخانه مجلس

۲۵/۳
فصل

۲۵ ۲۵
بهر و ...

تعمیرات

سفر به ...
...
...

...
...
...
...

...
...
...

...
...
...
...



...

...